



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/48

Модот


Жендэрийн дэд салбар хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Жендэрийн үндэсний хорооны 2021 оны “Жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загвар”-ын 2 дугаар бүлгийн 2.3, 2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, хөгжлийн зорилтот хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөнд жендэрийн тэгш байдлыг хангах талаар тусгагдсан бодлого, жендэрийн үндэсний хороо, дэд салбар хорооноос гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, чиг үүрэг бүхий жендэрийн дэд салбар хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, Дэд салбар хорооны ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Харъяа нутаг дэвсгэрийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлын хангах чиглэлээр тусгай ажлын төлөвлөгөө гаргаж, боловсруулж, хэрэгжилтийг тайлагнаж, арга зүйгээр хангаж ажиллахыг Жендэрийн дэд салбар хорооны (нарийн бичгийн дарга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.МӨНХ-ОРГИЛ

Сумын Засаг даргын 2026
03 дугаар сарын 31-ны
өдрийн #148 дугаар
захирамжийн 1 дүгээр
хавсралт

Дэд салбар хорооны дарга: Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүдэд

Малын үржил, бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан
мэргэжилтэн

Соёлын төвийн дарга

Эрүүл мэндийн төвийн дарга

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Ахмадын хорооны дарга

Сумын Засаг даргын 20...²⁶
...⁰³ дугаар сарын ³¹-ны
өдрийн...^{А/48}... дугаар
захирамжийн 2 дугаар
хавсралт

Жендэрийн дэд салбар хорооны ажилах журам
Нэг: Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Жендэрийн дэд хорооны / цаашид салбар хороо гэх/-ийн зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагааны болон түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулахад оршино.

1.2. Салбар хороо нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Төр, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, салбар дундын зохицуулалтыг хангаж, биелэлтэд хяналт тавих, бусад хууль тогтоомжийн хүрээнд ажиллана.

Хоёр: Салбар хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт

2.1. Салбар хороо нь 7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.2. Салбар хороо нь Сумын Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харъяа байгууллага, олон нийтийн байгууллагын оролцоог хангасан байх ба аль нэг хүйсийн төлөөлөл нь 40 хувиас доошгүй байна.

2.3. Салбар хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна. Ээлжит хуралдааныг хагас, бүтэн жилээр тутам хийнэ. Шаардлагатай тохиолдолд салбар хорооны даргын санаачлагаар эсвэл гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хуралдааныг хуралдуулж болно. Гишүүдийн 50-иас дээш хувь нь хуралдаанд ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.4. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг нийт гишүүдийн дийлэнхи олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2.5. Салбар хорооны ажлаа жилээр төлөвлөн, хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажиллана.

2.6. Хэлэлцсэн асуудлаар санал, зөвлөмж, салбар хорооны дарга / Засаг даргын/ захирамж, хурлын тэмдэглэл гаргана.

Гурав. Салбар хорооны чиг үүрэг.

3.1. Байгууллагын бодлого, хүний нөөцийн төлөвлөлт, хөтөлбөр төслийг жендэрийн мэдрэмжтэй болгоход арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

3.2. Байгууллагын хэмжээнд дагаж мөрддөг эрх зүйн баримт бичигт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан талаар дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж гарган байгууллагын удирдлагад танилцуулж, шаардлагатай тохиолдолд тухайн шатны ИТХ-ын даргад танилцуулж, тус үнэлгээнд үндэслэн арга хэмжээ авах шийдвэр гаргуулна.

3.3. Төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах, хэрэгжилтийг тайлагнах:

3.4. Салбар хорооны үйл ажиллагааны талаар албан хаагчдад мэдээлэл өгөх.

3.5. Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтад өртсөн талаарх мэдээллийг хүлээн авч, шалган хууль тогтоомжид заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.6. Жендэрийн эрх тэгш байдал, зохистой харилцаа, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дахь аливаа дарамтын талаарх мэдлэгийг албан хаагчдад олгох зорилгоор сургалт, сурталчилгааны ажлыг холбогдох байгууллага, газар, нэгжтэй хамтран зохион байгуулна.

3.7. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын хүрээнд эрэгтэй эмэгтэй хүний нийгэм, гэр бүлийн харилцаанд үүссэн тэгш бус байдлыг арилгахад чиглэсэн түр тусгай арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах,

3.8. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга хэмжээнд орон нутгийн иргэд, олон нийт залуучууд, зорилтот бүлгийн оролцоог хангах

3.9. Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, чадавхжуулах арга хэмжээг орон нутгийн хэмжээнд тогтмол зохион байгуулах, энэ чиглэлээр хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагааг өргөжүүлэх

3.10. Улс төр, төрийн алба, бизнес, иргэний нийгмийн байгууллагуудтай залуу манлайлагч эмэгтэйчүүдийг бэлтгэх, сургалт хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

3.11. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон төрөөс үзүүлж байгаа, бүх төрлийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох арга зүйн дэмжлэг үзүүлэх,

3.12. Охид эмэгтэйчүүд, өрх толгойлсон эцэг эх, хөгжлийн бэрхшээлтэй, иргэд (ажилтан албан хаагчид)-ийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, хөнгөлөлттэй зээл, тусламж үзүүлэх хөтөлбөрт хамрагдахад дэмжлэг үзүүлэх

3.13. Төрийн албыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах, эрэгтэй, эмэгтэй хүйсийн аль нэгэнд давуу эрх олгохгүй байх, тодорхой салбар, нэгж дэх хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах арга хэмжээ (түр тусгай арга хэмжээ) авах, хүний нөөцийн бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

3.14. Орон нутгийн алслагдмал нутгийн хүн ам, малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, явуулын эрүүл мэндийн үйлчилгээг тогтмол хүргэх нөхцөлийг бүрдүүлэх

3.15. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн нөхөн үржихүй болон эрүүл мэндийн чиглэлээр насны онцлогт тохируулан мэдлэг мэдээллийг олгоход дэмжлэг үзүүлэх

Дөрөв.Салбар хорооны бүрэлдэхүүний эрх үүрэг

4.1. Байгууллагын хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар явуулж буй үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцтай танилцаж, зөвлөмж өгөх бөгөөд энэ талаар байгууллагын удирдлагад тогтмол танилцуулна.

4.3.Салбар хорооны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.3.1.Салбар хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах;

4.3.2.Гишүүдэд үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;

4.4.Салбар хорооны гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.4.1.Хуралдаанд асуудал оруулж, хэлэлцүүлэх;

4.4.2.Салбар хорооны даргын өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, үр дүнг тайлагнах;

4.4.3.Хариуцсан чиглэлийн дагуу холбогдох мэдээ, тайлан, статистик тоо, баримт гаргаж өгөх;

4.4.4.Салбар хорооны гишүүн хуваарилагдсан гомдол, мэдээллийг шалган, танилцуулах, хуралдаанаар хэлэлцэн шийдвэр гаргахад холбогдох мэдээллийг бэлтгэн

урьдчилан хүргүүлэх.

4.5.Салбар хорооны нарийн бичгийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.5.1.Хуралдаанаар хэлэлцэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, салбар хорооны даргаар хянуулах, батлуулах;

4.5.2. Хуралдааны тэмдэглэл хөтлөх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3////

4.5.3. Холбогдох газар хэлтэс, хороонд хүргүүлэх;

4.5.4. Салбар хорооны үйл ажиллагааны мэдээллийг байгууллагын цахим хуудаст тухай бүр байршуулна.

Тав.Бусад

5.1. Байгууллагын удирдлага салбар хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

5.2. Салбар хорооны гишүүдийн идэвхи, ажлын гүйцэтгэлийг харгалзан жилээр урамшуулал олгож болно.

5.3. Ажлын тайланг нэгтгэж, холбогдох газар, хэлтэс, хороонд хүргүүлнэ.

_____000_____